

Хүчирхэг клонууд

Набүү гаригийн хатан халдлагад өртсөний дараа Оби-Ван Кеноби гэмт хэрэгтэнг мөшгиж яваад энэ халдлагыг Баунти Хантер гэгч этгээд зохион байгуулсныг илрүүлжээ. Мөн Баунти Хантер нь оддын системийн мэдээллээс арчигдсан Камино гэх гараг дээр амьдардгийг мэджээ. Энэ талаар Ёода мастерт илтгээд Баунти Хантерийн араас явж Камино гараг дээр юу байгааг судлах даалгавар авчээ. Тэрээр Камино гараг дээр очиход тэнд дайнд бэлтгэж маш олон клонуудыг үйлдвэрлэж байв. Дайн болоход нийт клонуудаас хамгийн хүчирхэг нэг салааг дайралтанд оруулна. Салааг сонгохдоо клонуудыг нэг эгнээнд жагсааж зогсоогоод дараалалж зогссон хэдэн клоныг сонгож авдаг. Харин салааны хүчийг салаанд байгаа клоны тоог уг салааны хамгийн сул хүчтэй клоны хүчээр үржсэн утгаар тодорхойлж байв. Яг одоо N клон жагсаалд зогсож байгаа ба Оби-Ван Кеноби яг эндээс сонгогдож болох салааны хүчийг Ёода мастерт мэдэгдэх хэрэгтэй болсон ба түүнд цаг маш бага байгаа учир танаас тусламж хүсэж байна.

Оролт: Эхний мөрөнд яг одоо жагсаалд байгаа клоны тоо $N \leq 100000$. Дараагийн мөрөнд клоны хүчийг илэрхийлэх F_1, F_2, \dots, F_N эерэг тоонууд өгөгдөнө. i -р клоны хүч $F_i \leq 10^{12}$.

Гаралт: Хамгийн хүчирхэг салааны хүчийг хэвлэ.

Жишээ оролт:

6

11 1 11 16 5 8

Жишээ гаралт:

22